



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 07 сарын 04 өдөр

Дугаар 1/2027

Арвайхээр сум

Тендерийн гүйцэтгэгчийг сонгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2023 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 76 дугаар дүгнэлтийн дагуу Арвайхээр хотын ерөнхий боловсролын Тэмүүлэл-Эрдэм сургуулийн спорт заалыг урлаг заал болгох засварын ажлыг 79,369,562 (далан есөн сая гурван зуун жаран есөн сая таван зуун жаран хоёр) төгрөгөөр Дөлгөөн арвай ХХК-иар гүйцэтгүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Тендерт шалгарсан аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан, ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, гэрээнд заасан хугацаанд хүлээж авахыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар (Т.Ариунболд)-т даалгасугай.

3. Шалгарсан аж ахуйн нэгжид гэрээнд заасан хуваарь, гүйцэтгэлийн дагуу санхүүжилт олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0830

D:My Doc. Zahiramj. Zasag darga